



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 4/1987

Номгон

“Бууцагаан сумын Цагаан голын эхийг хамгаалах”  
ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/ дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Бууцагаан сумын Цагаан голын эхийг хамгаалах” 30,000,000 (Гучин таван сая) төгрөгийн ажлыг тус сумын Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

2. Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу 08 дугаар сарын 09-ний өдрийн дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Бууцагаан сумын Засаг дарга (Д.Лхагвадорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх 30,000,000 (Гучин сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4. “Бууцагаан сумын Цагаан голын эхийг хамгаалах” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН